



"Бизнес Менежмент, Дижитал маркетинг менежмент" онлайн хөтөлбөр



Бизнесийн менежментийн хөтөлбөрийн танилцуулга

Энэхүү хөтөлбөрийн танилцуулгаар дамжуулж тантай уулзаж байгаадаа баяртай байна. АНУ-ыг эрдэм өвөртлөхөөр зориходоосоо өмнө Монголынхоо банкны салбарт 10 жил ажиллаж, олон зуун бизнесийн судалгааг ажлын шугамаар хийдэг байв. Банкинд зээлийн эдийн засагч, бизнес борлуулалтын менежерээр ажиллаж байсан туршлага маань хожим АНУ-д бизнесийн удирдлагын мастерийн зэргийг "Бизнес Менежмент"-ийн чиглэлээр хамгаалж, сургуулиа амжилттай төгсөхөд ихээхэн чухал хувь нэмэр оруулж билээ. Америкийн бизнесийн сургуулиас олж авсан мэдлэгтээ үндэслэн эх орныхоо бизнесийн хөрсийг шинжлэн харахад бизнесүүдийн сайжруулах хэрэгтэй байгаа менежментийн олон аргуудыг хэрэгжүүлэхсэн гэсэн мөрөөдөл маань "Бизнес менежмент"-ийн онлайн хөтөлбөрөөр маань дамжуулан биелэх болно гэж бодохоор үнэхээр их сэтгэл хөдлөж байна.



Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд хүн бүр өөр өөрийн бизнесүүдийг эрхлэхийг хүсч тэмүүлэх болжээ. Харамсалтай нь өөрийнхөө боломжийг бизнес болгон хувиргах алсын хараагаа харж чадахгүй, бизнесийн үйл ажиллагаа эхлүүлсэн ч хэрхэн менежментийг хийх мэдлэг чадвар дутмагаас олон бизнесүүд үүд хаалгаа барьж байгааг бид өдөр тутамдаа харж байна.

Хэдий бизнес эхлүүлэх мөнгөтэй байгаад бизнес эхлүүлсэн ч аргаа олохгүй, орлого ашиггүй ажилласаар нэг л мэдэхэд эхлүүлсэн бизнес нь та бидний толгойны өвчин болох тохиолдолууд бий. Үүнээс харахад бизнесийг МӨНГӨНӨӨС ГАДНА МЭДЛЭГЭЭР хийдэг гэдгийг сургуульд сурч байх хугацаандаа сайтар ойлгож авч сурч мэдсэн туршлагатаа тулгуурлан өөрийн онлайн бизнесийг 6 жил амжилттай эрхлэж байна. Харин танд би өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан мэдлэг, туршлага, боловсролоосоо хуваалцаж, таны өөрийн гайхалтай бизнесийг цаашид олон улсын түвшинд хүргэх менежментийн аргачлалыг танилцуулж, дэлхий шилдэг бизнесүүдээс туршлага стратегиудыг судлах боломжийг олгож, бизнесийн алсын хараагаа томоос том харж сэтгэхэд хөтөлбөрөөрөө дамжуулан туслах юм. Хэрвээ та одоогоор бизнес эхлүүлэх санаатай байгаа боловч учраа сайн ололгүй төөрч байгаа бол ганцаараа бодоод явах бус бизнес санаагаа харилцан ярилцан, чиглүүлэг авч ажилласнаар өөрийн хүссэн бизнесээ эхлүүлэх эхний алхамаа хийх мэдлэг чадварыг энэхүү хөтөлбөрөөс авах болно гэдэгт итгэлтэй байна. Гагцхүү таны бизнес эрхлэх чинхүү хүсэл зориг байгаа цагт бүх боломж таны ҮҮД хаалгыг тогшоод хүлээж байдаг гэдэгт итгээрэй.

Мөн та ажлынхаа хажуугаар давхар бизнес эрхлэх нууцхан мөрөөдөлтэй авдар дотроо нуусан алт эрдэнэсээ одоо л яг гаргах цаг болсон гэж бодож байна. Миний хувьд ч мөн анх өөрийн бизнесийг ажлынхаа хажуугаар эхлүүлж түүнээс хойш 2 жилийн дараа бие даан бизнесийн үйл ажиллагаандаа 100 хувь анхаарлаа төвлөрүүлэх болсон юм. Энэ бол үнэхээр гайхалтай бас баҳархмаар мэдрэмж байдаг шүү.


Таныг би эх орондоо төдийгүй олон улсын түвшинд бизнесийн үйл ажиллагаагаа хил хязгааргүйгээр эрхлэх, түүнийхээ төлөө хөдөлмөрлөж чадах сэтгэлгээ, ур чадварыг хөтөлбөрөөсөө суралцаж, дэлхийд үнэлэгдсэн менежментийн арга ухааныг өөрийн бизнестээ нэвтрүүлж, орчин цагтаа хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн эзэн нь болж өөрөө баҳархан зогсох хүн байхыг маш их хүсч байна. Ингээд танд өөрийн болон хөтөлбөрийнхөө талаар танилцуулж байна.

Төмөрбаатар овогтой Гантуяа

Миний түүх

Боловсрол

- 1999 онд Сэлэнгэ аймаг Мандал сумын 1 дүгээр сургуулийг төгссөн.
- 2003 онд нягтлан бодогч, санхүүгийн шинжээч мэргэжлээр бакалаврын зэргээ хамгаалж, төгссөн.
- 2012 онд Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийг англи хэлний орчуулагч мэргэжлээр төгссөн.
- 2013 онд АНУ-ын Кентаки мужид Campbellsville их сургуулийн англи хэлний бэлтгэлийг дүүргэсэн.
(ESL)
- 2014 онд АНУ-ын California University Management and Science их сургуулийн англи хэлний бэлтгэлд дүүргэсэн.
- 2016 онд АНУ-ын California University Management and Science их сургуулийг Бизнесийн Удирдлагын Магистрын зэргийг "Бизнес Менежмент"-ийн чиглэлээр төгссөн.
- 2018 онд АНУ-д мэргэжил дээшлүүлэх "Visionary Business School" Entrepreneur сургалтанд хамрагдсан.
- 2019 онд Ука Төмөр "Трафик-1" сургалтанд оролцсон.
- 2020 онд "School of Positive Transformation" онлайн сургуульд суралцан "Mindfulness and Meditation Teacher" болсон.
- 2021 GenuisU "Боловсролын шинэчлэл" олон улсын хөтөлбөр




Ажлын туршлага

- 2004 онд ХасБанкинд зээлийн эдийн засагч
- 2006 онд ХасБанкинд зээлийн менежер
- 2008 онд ХасБанкинд зээлийн ахлах мэргэжилтэн
- 2008 онд ХасБанк Төв алба Бүтээгдэхүүн хариуцсан менежер
- 2009 онд ХасБанк Эрсдлийн менежер
- 2010 онд ХасБанк Бизнес Борлуулалтын менежер
- 2013 онд Салбарын захирлаар Монголдоо тус тус ажилласан туршлагатай.
- 2017 онд Бизнес менежментийн магистрын зэргийн дагуу АНУ-д мэргэжлээрээ 1 жил ажилласан.

Өөрийн бизнесийн туршлага

- 2017 онд өөрийн онлайн бизнесийг нээж залуучууддаа зориулсан "Америкт суралцах миний төлөвлөгөө" онлайн хөтөлбөрийг боловсруулж үүний үр дүнд 300 гаруй хүмүүс АНУ-д өөрөө болон гэр бүлийн гишүүдийн хамтаар сурч амьдарч, аялсан байна.
- 2018 онд "Америкт сурч амьдрах боломжууд" номоо бичиж, олны хүртээл болгосон.
- 2018 онд ахлах болон дунд ангийн сурагчдад зориулсан АНУ-д тэтгэлэгтэй суралцах бэлтгэл "PEACE" онлайн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлсээр байна.
- 2019 онд ЕБС-ийн сурагчдад зориулсан "All Star" онлайн англи хэлний клубыг 2 охины хамт үйл ажиллагааг нь эхлүүлсэн.
- 2020 онд "Амьдралын Менежмент" дижитал зорилгын дэвтрийг бүтээсэн.
- 2020 онд "Бизнес менежмент, Дижитал маркетинг менежмент" онлайн хөтөлбөрийг гаргасан.
- 2021 онд "Бизнес менежмент, Дижитал маркетинг менежмент" онлайн хөтөлбөрийн оролцогчдын хамт онлайн эвент сургалтуудыг зохион байгуулсан.



"Бизнес Менежмент,
Дижитал Маркетинг
менежмент"
онлайн хөтөлбөрийн
танилцуулга

"Бизнес Менежмент, Дижитал Маркетинг менежмент" онлайн хөтөлбөр хэнд зориулагдсан бэ?

- Мэргэжлийнхээ дагуу бизнес эрхлэх хүсэлтэй бол
- Ажлынхаа хажуугаар нэмэлт орлоготой болох хүсэлтэй бол
- Дэлхийд танигдсан брэндийг бүтээх мөрөөдөлтэй бол
- Бизнесийн менежментийн талаар мэдлэгтэй болох хүсэлтэй менежер бол
- Гэртээ хүүхдүүдээ өсгөхийн зэрэгцээ өөрийгөө хөгжүүлж, бизнес эрхлэх хүсэлтэй аав ээжүүд бол
- Энтерпрёнер болох чин хүсэл тэмүүлэлтэй бол
- Бизнес эрхлэх чин сэтгэл байвч хаанаас юунаас эхлэхээ мэдэхгүй байгаа бол

"Бизнес менежмент, Дижитал Маркетинг менежмент" онлайн хөтөлбөр танд зориулагдсан болно.



Хэрхэн суралцах вэ?

7 хоног бүр шинэ модулиуд судлах

7 хоног бүр шинэ модулиудын 2-3 хичээлийг судлаж, өөрийн бизнесийн менежментийг хийх дасгалууд болон *worksheet* ажиллана.

Долоо хоног тутамд онлайн уулзалтандаа оролцох


Ментор зөвлөхүүдтэй хамт долоо хоног тутамд онлайн уулзалтандаа оролцож, асуултууд асууж, хариултуудыг авна.

Сургалтын платформоос хичээлийн видеог үзэх

Хичээлийн видео болон гарын авлагуудыг зөвхөн хөтөлбөрийн ооолцогчдодоо зориулсан онлайн сургалтын платформоос судлана.

Ганцаарчилсан зөвлөгөө тусламж

Сардаа 1 удаа цаг тохирон ментор, болон бизнесийн зөвлөхтэйгөө асуудал бэрхшээлээ ярилцан, шийдлийг олоход туслана.





Модуль-1 Бизнесийн алсын хараа

Модуль-2

Бизнесийн менежмент
болон менежментийн
процесс





Модуль-3

Бизнес


төлөвлөгөө

Модуль-4

Бизнесийн

зохион

байгуулалт





Модуль-5

Бизнесээ

удирдан

чиглүүлэх

нь

Модуль-6

Бизнесийн

хяналт, үр

дүн



"Дижитал маркетинг менежмент" БОНУС СУРГАЛТ

2 сар эрчимтэй "Бизнес Менежмент" талаар судалж, өөрийн бизнесийн менежментийг хийн, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хэрхэн зах зээлд таниулж, борлуулалтаа өсгөх дараагийн алхам болох "Дижитал маркетинг менежмент" -ээс суралцаж, бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх 10 сарын практик, дадлагыг бизнесийн ментор, зөвлөхүүдийн заавар зөвлөгөөний тусламжийг авч хэрэгжүүлж, хийх болно. Нийт бүтэн жил буюу 12 сар суралцана.






Сар бүр судлах Дижитал маркетинг менежмент 10 төрөл

- Social media marketing
- Website or blog
- Search Engine Optimization
- Paid Ads Platform
- Email marketing
- Affiliate Marketing
- Influencer Marketing
- Web Analytics
- Pixel
- Content Marketing



"Бизнес
Менежмент
Дижитал
Маркетинг
Менежмент"
онлайн хөтөлбөр
Төлбөр: 2 сая төгрөг

Хөтөлбөрт хэрхэн оролцох вэ?



Хөтөлбөрт оролцох хүсэлтээ илгээнэ.
Энд дарж бүртгэлийн маягтыг бөглөнө үү.



Төлбөр 2 сая төгрөг төлж, бүртгэлээ
баталгаажуулна.



Хөтөлбөрт оролцох
урилгаа имэйлээр хүлээж авна:




Бидэнтэй холбоо барих:



Имэйл:

info@mon-usa.com



Монгол дахь хөтөлбөрийн
менежер

Т.Болортая

Холбогдох утас: 80063395



facebook: Mon-Usa Education
instagram: Mon-Usa Education
Youtube: Mon-Usa Education
e-mail: info@mon-usa.com
website: <https://mon-usa.com/>